



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
Ү ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 05

Зуунмод

Баянчандмань сумын хилийн цэсэд
өөрчлөлт оруулах санал уламжлах тухай

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн Нийслэлтэй хил залгаа Баянчандмань сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах тухай санал, мэдээлэл, түүнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол Улсын засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 3-р хавсралтын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Баянчандмань сум, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэх хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг дэмжиж Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

2. Төв аймгийн Баянчандмань сум, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэх хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг нэгдүгээр, Баянчандмань сумын нутаг дэвсгэрт оруулах өөрчлөлтийн тооцоог хоёрдугаар, Баянчандмань сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах нутаг дэвсгэрийн газрын зургийг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Баянчандмань сумын хилийн цэсийг шинэчлэн тогтоолгохтой холбоотой материалыг “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 2 дахь зүйлийн 19-д заасны дагуу бүрдүүлж газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАМБАЛСҮРЭН

0100009

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 06 сарын 28 -ны өдрийн
5 дугаар хуралдааны 05 дугаар
 тогтоолын 01 -р хавсралт

**БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ХИЛИЙН ЦЭСИЙГ
 ШИНЭЧИЛЭН ӨӨРЧЛӨХ САНАЛ**

№	Хилийн цэсийн тоотын нэр	Өргөрөг /WGS84/	Уртраг /WGS84/
1	1827.6 тоот	48°16'41.7000"	106°00'53.9900"
2	1761.0 тоот	48°17'28.3000"	106°02'02.4000"
3	Шавартын даваа /1525.0 тоот/	48°18'07.6000"	106°03'45.0000"
4	1612.4 тоот	48°18'27.2900"	106°04'30.0000"
5	Баянцагааны даваа /1390.6 тоот/, Баянцагааны нурууг хярлан	48°20'41.6900"	106°06'17.7000"
6	1385.2 тоот	48°21'56.3000"	106°09'12.9000"
7	Шивэртийн голын бэлчир, Шивэртийн голыг уруудаж	48°21'18.0000"	106°11'27.5900"
8	Шарын гол-Шивэрт голын уулзвар, засмал замын	48°17'35.1000"	106°11'45.5000"
9	Шарын голын гүүр, хар замаар хойш эргэж	48°18'00.1000"	106°13'09.5900"
10	Бага цагаан сүүжийн хөтөл, зүүн тийш	48°18'43.4000"	106°13'04.3000"
11	1373.0 тоот	48°19'09.6900"	106°13'48.5900"
12	Бага цагаан сүүж /1351.0 тоот/	48°19'38.5000"	106°15'32.7900"
13	1404.6 тоот	48°19'57.2000"	106°17'38.9000"
14	1502.0 тоот	48°19'32.3900"	106°19'10.5000"
15	1646.5 тоот	48°19'02.8000"	106°22'54.6000"
16	Шарын даваа /1525.0 тоот/	48°17'57.7000"	106°21'42.1900"
17	Баян хүнхэр /1707.0 тоот/	48°17'23.5000"	106°21'13.7000"
18	Согоо туул /1758.2 тоот/	48°15'26.2000"	106°21'47.3000"
19	1764.0 тоот	48°14'47.2000"	106°22'03.8000"
20	1753.0 тоот	48°11'47.9900"	106°24'27.9000"
21	1725.4 тоот	48°08'56.5000"	106°25'43.7000"
22	1725,4 тоот өндөрлөгөөс шулуун шугамаар холбож Улаанбаатар Дархан чиглэлийн авто замтай огтолцох	48°08'22.23"	106°25'14.10"
23	Замтын горхи-Дэлгэр булгийн уулзвар	48°04'19.9900"	106°28'40.4900"
24	Бөөр толгой	48°02'31.0900"	106°27'39.9900"
25	Халзангийн даваа	48°05'17.2900"	106°21'33.0000"
26	Хайртхаан /1815.3 тоот/	48°04'19.0900"	106°21'22.5000"
27	Гурын давааны хойт хөтөл, замаар	48°03'43.5900"	106°20'23.9900"
28	Хавцгайтын булгийн урд хөтөл	48°06'48.7000"	106°17'42.7000"
29	Хавцгайтын булаг, Хавцгайтын голыг уруудан	48°07'28.9000"	106°18'04.8900"
30	Адгийн худаг	48°08'40.0000"	106°12'57.4000"
31	Их хонгор /1534.5 тоот/	48°07'20.1900"	106°09'19.1900"
32	Өлийн даваа	48°07'44.4900"	106°06'58.2000"
33	Гахайн бор /1576.5 тоот/	48°08'32.4900"	106°05'29.2900"
34	Мухдагийн даваа	48°09'30.3000"	106°04'45.4000"
35	Цагаан даваа /1402.0 тоот/	48°12'35.0900"	106°04'20.6900"
36	Ангархайн даваа /1328.7 тоот/	48°13'20.2000"	106°04'56.6000"




Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
1031 оны 06 сарын 06-ны өдрийн
дугаар хуралдааны 05 дүгээр
тогтоолын 08-р хавсралт

БАЯНЧАНДМАНЬ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРОХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТООЦОО

/Талбайн хэмжээ га-аар/

№	Сумын нэр	Одоо байгаа		Өөрчлөлтөөр нийт талбай	Нэмэгдэх, хасагдах талбай	Хөдөө аж ахуй газар га-аар	Хот тосгон бусад суурины газар	Усан сан бүхий газар	Ойн сан бүхий газар	Зам шугам сүлжээний газар	Улсын тусгай хэрэгцээ газар га-аар
		Аймгийн ГНС	тайлангаар								
1	Баянчандмань сум	61315.0		61483.6	+168.6	44837.93	4041.97 +168.6	28	10566	719.4700	1121.63
2	Сонгинохайрхан дүүрэг				-168.6						
Нийт				61483.6		44837.93	4210.57	28	10566	719.4700	1121.63

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 06 сарын 23-ны өдрийн
7 дугаар хуралдааны 05 дугаар
 тогтоолын 03 дугаар хавсралт



Баянчандмань сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах нутаг дэвсгэрийн газрын зураг

